



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦӨМИЙН ФИЗИК СУДАЛГААНЫ ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/70/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Аудитор: Д.Зэндмэнэ
Утас: 261628 Цахим хаяг: zendmened@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК
Захирал: С.Тунгалаг
Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Албан шаардлага.....	15
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/384
танай _____-ны № _____-т

ЦӨМИЙН ФИЗИК СУДАЛГААНЫ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.БОЛОРТУЯА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын хүүхдийн ордны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цөмийн физик судалгааны төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2022\0225 Auditin 2 Gazar - 42.Docx

701050501

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,328,610.85	104,154,681.58
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
33	АВЛАГА	191,028.01	31,221,255.70
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	191,028.01	59,028.70
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	31,162,227.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,137,582.84	72,933,425.88
351	Түүхий эд материал	209,000.00	70,546,151.04
35110	Тусгай зориулалттай материал	209,000.00	70,546,151.04
354	Хангамжийн материал	1,928,582.84	2,387,274.84
35440	Түлш шатах тослох материал	-	54,600.00
35470	Бусад хангамжийн материал	1,928,582.84	2,332,674.84
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	165,739,586.73	483,694,350.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	165,739,586.73	483,694,350.13
392	Биет хөрөнгө	165,307,734.45	483,408,350.13
39205	Машин, тоног төхөөрөмж	257,221,929.40	641,232,009.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	(96,838,902.64)	(161,812,778.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,711,800.00	8,667,810.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,847,092.31)	(5,738,690.61)
39217	Номын фонд	1,060,000.00	1,060,000.00
393	Биет бус хөрөнгө	431,852.28	286,000.00
39301	Программ хангамж	1,727,408.76	2,013,408.76
39302	Хасагдуулаг	(1,295,556.48)	(1,727,408.76)
39303	Бусад биет бус хөрөнгө	539,000.00	-
39304	Хасагдуулаг	(539,000.00)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	168,068,197.58	587,849,031.71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	191,028.01	2,489,400.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	191,028.01	2,489,400.00
413	Өглөг	191,028.01	2,489,400.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	-	2,489,400.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,489,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	167,877,169.57	585,359,631.71
51	Засгийн газрын хувь оролцоо	167,877,169.57	585,359,631.71
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	177,196,868.00	177,196,868.00
51101	Өмч: -Төрийн өмч	177,196,868.00	177,196,868.00
512	Хуримтлагдсан үр дүн	(9,319,698.43)	408,162,763.71
51210	Өмнөх үеийн үр дүн	(9,319,698.43)	(9,319,698.43)
51220	Тайлант үеийн үр дүн	-	417,482,462.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	168,068,197.58	587,849,031.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	362,169,502.58	845,051,890.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,605,002.58	437,718,590.67
120	Нийтлэг татварын бус орлого	18,605,002.58	368,345,369.63
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	18,605,002.58	368,345,369.63
120017	Үнэ төлбөргүй хүлээж авсан -Үндсэн хөрөнгө	18,605,002.58	368,345,369.63
122	Тусламжийн орлого	-	69,373,221.04
122001	Хандив тусламж/дотоод/	-	69,373,221.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	343,564,500.00	407,333,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	343,564,500.00	341,533,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	343,564,500.00	341,533,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	65,800,000.00
ДТ(131104)	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	-	65,800,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	391,059,447.11	427,569,428.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	391,059,447.11	427,569,428.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	383,485,036.94	400,932,915.41
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	286,557,073.00	267,428,383.53
210101	Цалин	222,185,250.82	225,446,483.23
210102	Нэмэгдэл цалин	40,209,822.18	27,431,905.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,162,000.00	14,549,995.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,903,215.00	33,671,261.73
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	25,214,151.00	24,698,162.12
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,966,372.00	2,749,883.91
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,292,456.00	2,139,427.19
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	355,441.00	333,780.70
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,074,795.00	3,750,007.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,460,038.13	12,038,834.42
210301	Гэрэл цахилгааны зардал	11,542,152.40	10,260,797.71
210302	Түлш, халаалтын зардал	1,917,885.73	1,778,036.71
2104	Хангамж, бараа материалын зардал	703,763.70	5,687,900.00
210401	Бичиг хэргийн материал	282,000.00	5,519,200.00
210402	Тээвэр, шатахууны зардал	182,000.00	45,500.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	239,763.70	123,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	366,000.00	9,369,219.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	201,000.00	5,643,419.50
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	3,494,800.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	165,000.00	231,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,494,947.11	72,737,316.23
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,494,947.11	72,737,316.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,574,410.17	26,636,513.12
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,574,410.17	26,636,513.12
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,574,410.17	-
213302	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	26,636,513.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(28,889,944.53)	417,482,462.14
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(28,889,944.53)	417,482,462.14

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	177,196,868.00	28,084,156.70	205,281,024.70
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	177,196,868.00	28,084,156.70	205,281,024.70
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	(28,889,944.53)	(28,889,944.53)
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	177,196,868.00	(9,319,698.43)	167,877,169.57
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	177,196,868.00	(9,319,698.43)	167,877,169.57
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	417,482,462.14	417,482,462.14
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	177,196,868.00	408,162,763.71	585,359,631.71

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	343,564,500.00	407,333,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	343,564,500.00	407,333,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	343,564,500.00	341,533,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	343,564,500.00	341,533,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	65,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	65,800,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	343,564,500.00	407,333,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	343,564,500.00	407,333,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	335,990,089.83	380,696,786.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286,557,073.00	267,428,383.53
210101	Үндсэн цалин	222,185,250.82	219,648,551.76
210102	Нэмэгдэл	40,209,822.18	31,651,838.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,162,000.00	16,127,993.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,903,215.00	33,730,290.43
210201	Тэтгэврийн даатгал	25,214,151.00	24,757,190.82
210202	Тэтгэмжийн даатгал	2,966,372.00	2,749,883.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,292,456.00	2,139,427.19
210204	Ажилгүйдлийн даатгал	355,441.00	333,780.70
210205	Эрүүл мэндийн даатгал	4,074,795.00	3,750,007.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,460,038.13	11,997,834.42
210301	Гэрэл, цахилгаан	11,542,152.40	9,036,779.60
210302	Түлш, халаалт	1,917,885.73	2,961,054.82
2104	Хангамж, бараа материалын зардал	703,763.70	511,100.00
210401	Бичиг хэрэг	282,000.00	246,800.00
210402	Тээвэр, шатахуун	182,000.00	141,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	239,763.70	123,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	366,000.00	67,029,178.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	201,000.00	65,798,178.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	231,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,574,410.17	26,636,513.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,574,410.17	26,636,513.12
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	-
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	341,533,300.00	314,898,608.38	26,634,691.62
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	341,533,300.00	314,898,608.38	26,634,691.62
210	Бараа, үйлчилгээний зардал	341,533,300.00	314,898,608.38	26,634,691.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286,608,300.00	267,428,383.53	19,179,916.47
210101	Үндсэн цалин	216,254,600.00	219,648,551.76	(3,393,951.76)
210102	Нэмэгдэл	61,572,100.00	31,651,838.19	29,920,261.81
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	8,781,600.00	16,127,993.58	(7,346,393.58)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,692,200.00	33,730,290.43	4,961,909.57
210201	Тэтгэврийн даатгал	27,227,800.00	24,757,190.82	2,470,609.18
210202	Тэтгэмжийн даатгал	2,866,100.00	2,749,883.91	116,216.09
210203	ҮОМШӨ ний даатгал	2,292,900.00	2,139,427.19	153,472.81
210204	Ажилгүйдлийн даатгал	573,200.00	333,780.70	239,419.30
210205	Эрүүл мэндийн даатгал	5,732,200.00	3,750,007.81	1,982,192.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,387,600.00	11,997,834.42	2,389,765.58
210301	Гэрэл цахилгаан	7,872,600.00	9,036,779.60	(1,164,179.60)
210302	Түлш, халаалт	6,515,000.00	2,961,054.82	3,553,945.18
2104	Хангамж, бараа материалын зардал	614,200.00	511,100.00	103,100.00
210401	Бичиг хэрэг	246,800.00	246,800.00	-
210402	Тээвэр (шатахуун)	159,300.00	141,100.00	18,200.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	208,100.00	123,200.00	84,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,231,000.00	1,231,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	1,000,000.00	-
210806	Мэдээллийн технологийн зардал	231,000.00	231,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	341,533,300.00	314,898,608.38	26,634,691.62
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	341,533,300.00	314,898,608.38	26,634,691.62
131001	Улсын төсвөөс санхүүжих	341,533,300.00	314,898,608.38	26,634,691.62
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	20	20	-
620001	Удирдах ажилтан	1	1	-
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18	-
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	65,800,000.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	65,800,000.00
210	Бараа, үйлчилгээний зардал	-	65,798,178.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	65,798,178.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	65,798,178.50
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,821.50
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,821.50
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,821.50
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	65,800,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	65,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	65,800,000.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	-
620001	Удирдах ажилтан	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-
620003	Үйлчлэх ажилтан	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цөмийн физик судалгааны төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад зардлын зүйл анги, үндсэн хөрөнгөтэй холбоотой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, аудиторов туслах Т.Оюун, Г.Ариунболд, Б.Ган-Эрдэнэ нар гүйцэтгэж хяналтыг чанарын хяналтын менежер С.Сожидмаа, захирал С.Тунгалаг нар тус тус хэрэгжүүлсэн.

Цөмийн физик судалгааны төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цөмийн физик судалгааны төв нь Монгол Улсын Засгийн газраас баталсан үндсэн чиглэлийн хүрээнд Үйл ажиллагаагаа явуулдаг Монгол Улсын Их сургуулийн харьяаны эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цөмийн физик судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн нийт зардлын 343,739.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,437.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цөмийн физик судалгааны төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 419,780.4 мянган төгрөгөөр буюу 3.5 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Авлага	191.0	31,221.3	31,030.2
Бараа материал	2,137.6	72,933.4	70,795.8
Үндсэн хөрөнгө	165,739.6	483,694.4	317,954.8
Нийт хөрөнгийн дүн	168,068.2	587,849.0	419,780.8
Богино хугацаат өр төлбөр	191.0	2,489.0	2,298.4
Засгийн газрын хувь оролцоо	167,877.2	585,359.6	417,482.5
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/Өмчийн дүн	168,068.2	587,849.0	419,780.8

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл 31,030.2 мянган төгрөгөөр өссөн нь хэрэгжиж буй 3 суурь судалгааны төслийн төлбөртэй үйлчилгээний авлага нэмэгдсэн;
- Бараа материалын дансны үлдэгдэл 70,795.8 мянган төгрөгөөр өссөн нь олон улсын mon0012 төслийн хандиваар 693,732.2 мянган төгрөгийн химийн ялтас хүлээн авсан;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 317,954.7 мянган төгрөгөөр өссөн нь олон улсын mon0012 төслийн хандиваар 368,345.4 мянган төгрөгийн судалгаа шинжилгээний төхөөрөмж хүлээн авсан;
- Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл 2,298.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны санхүүгийн тайлангийн аудитын төлбөрийг бүртгэсэн;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 417,482.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй тус тус холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Цөмийн физик судалгааны төвийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 570,547.2 мянган төгрөгийг төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 341,533.3 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Тайлант хугацаанд тус Төсөв санхүү эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг нэмж тодотгох хүсэлт хүргүүлээгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг улсын төсвөөс 341,533.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, бүрэн санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 314,989.6 мянган төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 19,179.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4,961.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,389.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71805	Шинжлэх ухаан, технологи	341,533.3	314,989.6	26,543.7	92.2
2	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	341,533.3	314,989.6	26,543.7	92.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Суурь судалгаа хөгжүүлэх 3 төслийн 65,800.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд зарцуулагдсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 92.2 хувийн биелэлттэй, 7.8 хувь буюу 26,543.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Цөмийн физик судалгааны төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 173 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 9 мэдээлэл хугацаа хоцорч, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4 удаагийн зарлагын 3 удаагийн 44,891,811.62 төгрөгийн мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант хугацаанд 26,636.5 мянган төгрөг буюу 8 хувийн хэмнэлт гаргаж ажилласан боловч Монгол Улсын Засгийн газрын 43 дугаар тогтоолд зааснаас 2 хувиар дутуу байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авалтын гэрээний хэрэгжилт Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын заалттай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 119,522.2 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчил илрүүлснийг бүрэн залруулж, өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад давтан гаргаагүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 21 мэдээг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд 1 албан шаардлагын биелүүлээгүй, 9,147.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн актыг 100 хувь барагдуулж, 85,157.7 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	-	-	1	-	-
Төлбөрийн акт	2	9,147.1	2	9,147.1	-	-	100
Зөвлөмж	3	85,157.7	3	85,157.7	-	-	100
Нийт дүн	6	94,304.8	5	94,304.8	1	-	83.3

Шилэн дансны цахим хуудсанд 21 мэдээг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд 1 албан шаардлагын биелүүлээгүй, давтан гаргасан зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага өгөх.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цөмийн физик судалгааны төвийн хэмжээнд хэрэгжиж дууссан төсөл, хөтөлбөрүүдийг, шинжлэх ухаан технологийн сангийн итгэмжлэгдсэн хадгалагчид хүлээлгэн өгсөн актыг авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 190,040.7 мянган төгрөгийн 21 алдаа, зөрчил илэрснээс 190,040.7 мянган төгрөгийн 16 алдааг залруулж, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын 3 дугаар улирлын тайланг цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлээс 62,092.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Хавсран ажилласан хоногийг илүү тооцооноос 3 ажилтанд 238.6 мянган төгрөгийг илүү олгосон;
- Төлбөрийн баримтгүй 4 байгууллагын 2,001.6 мянган төгрөг, и-баримтаас зөрүүтэй 16 байгууллагын 1,773.9 мянган төгрөгийн ажил гүйлгээ бүртгэсэн;
- Эрдэм шинжилгээний суурь судалгааны төслийн 4 ажилтанд батлагдсан удирдамжгүй, томилолтын хуудасгүйгээр 445.8 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгосон;
- Харилцагч байгууллагын нэхэмжлэхгүйгээр 579.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн;
- Төсөл хөтөлбөрийн орлогыг санхүүгийн тайланд, санхүүжсэн дүнгээс 9,888.3 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Төсөл хөтөлбөрийн урьдчилж орсон орлого, урьдчилж гарсан зардлыг нийт 19,776.5 мянган төгрөгөөр сөрөг утгатайгаар бууруулж бүртгэсэн.
- Актын төлбөрийг санхүүгийн тайлангийн богино хугацаат өр төлбөрийн хэсэгт сөрөг утгатайгаар 8,956.1 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасан;
- Бараа материалын шинж чанартай 9 нэр төрлийн 983.7 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн;
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 8,956.1 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй;
- Нэмэлт санхүүжилтээс 6 байгууллага, 2 иргэнд 3,830.4 мянган төгрөгийг шилжүүлэхдээ өглөгийн дансанд бичилт хийхгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан;
- Нийт 10 байгууллагын 24,141.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдлээс 4 байгууллагын 24,082.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Нэмэлт санхүүжилтийн дансаар 2 ажилтны гадаад томилолтын зардалд 7,080.0 мянган төгрөгийг олгохдоо томилолтыг урьдчилан хаалгаж, зардлын дансанд бүртгэж тайлагнасан;
- Санхүүгийн байдлын тайлан дахь түлш шатах тослох материалын эцсийн үлдэгдэл нь бараа материалын тодруулгын дүнгээс 18.2 мянган төгрөгийн зөрүүтэй;
- Тайлант хугацаанд 87,380.2 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 5 нэр төрлийн хөрөнгөнд 7,249.3 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг баримтлаагүй 1 жилээр тооцооноос нийт 43 нэр төрлийн 32,088.7 төгрөгийн үндсэн хөрөнгийг үлдэх өртөггүй тайлагнасан;

4.2 Албан шаардлага

Санхүүгийн тайланг аудитад ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.5-д “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга” заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар баталсан зардлын нэр төрлийг санхүүгийн программд нэмж оруулаагүй, нэмэлт санхүүжилтийн тайлан, төсвийн тохируулгын тайланг бэлтгээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн программ хангамж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлын зүйл ангийг нэмж оруулах

Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 10 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрх бүхий байгууллагад уламжлан дахин үнэлгээ хийх, данснаас хасах асуудлыг шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Д/Д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
	Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар															
1	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ-2022/70/Н А-СТА-ТШЗ	2021 оны 1 -9 сарын цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлээрх 26 ажилтанд олговол зохих 195,370.7 мянган төгрөгийн цалин хөлсний дүнг, ХХОАТ-ын 3 улирлын тайлангийн дүнтэй тулгахад 25 хүний 133,278.4 мянган төгрөгөөр тайлагнасан нь цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс 62,092.2 мянган төгрөгөөр дутуу байна.	Завсрын аудитаар залруулсан.	1	62,092.2	1	62,092.2	-	-	-	-	-	-	-	-

Цөмийн физик судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ-2022/70/Н А-СТА-ТШЗ	2021 оны 1-9 дүгээр сарын цалин хөлсний тооцооллыг давтан шалгахад 2021 оны 2 дугаар сард хавсран ажилласан хоногийг илүү тооцсоноос 3 ажилтанд 238.6 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.	Завсрын аудитаар залруулсан.	1	238.6	1	238.6	-	-	-	-	-	-	-	-
3	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ-2022/70/Н А-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд 4 байгууллагын 2,001.5 мянган төгрөгийн төлбөрийн И баримтгүй, 16 байгууллагын 1,773.8 мянган төгрөгийн И баримтаас дутуу дүнтэй ажил гүйлгээг бүртгэж тайлагнасан байна.	Завсрын аудитаар залруулсан.	1	3,775.5	1	3,775.5	-	-	-	-	-	-	-	-
4	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ-2022/70/Н А-СТА-ТШЗ	"Хүрээлэн буй орчин, биологийн объектыг шинжлэх цөмийн физикийн арга зүйн судалгаа" сэдэвт эрдэм шинжилгээний суурь	Завсрын аудитаар залруулсан.	1	445.8	1	445.8	-	-	-	-	-	-	-	-

Цөмийн физик судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			судалгааны төслийн 4 ажилтанд томилолтын хуудасгүй, батлагдсан удирдамжгүй 445.7 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгосон байна.													
5	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	УБЦТС ХК-д нэхэмжлэхгүйгээр р 579.1 мянган төгрөгийн гүйлгээг бүртгэсэн.	Завсрын аудитаар залруулсан.	1	579.1	1	579.1	-	-	-	-	-	-	-	-
6	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	Нэмэлт санхүүжилтийн дансаар санхүүжүүлсэн 3 төсөл хөтөлбөрийн 43,050.0 мянган төгрөгийн орлогыг, санхүүгийн тайланд тайланд урьдчилж орсон орлогоор бүртгэж тайлагнахдаа 33,161.7 мянган төгрөгөөр буюу 9,888.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	Завсрын аудитаар залруулсан.	1	9,888.3	1	9,888.3	-	-	-	-	-	-	-	-

Цөмийн физик судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

7	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ-2022/70/Н А-СТА-ТШЗ	3 төсөл хөтөлбөрийн 43,050.0 мянган төгрөгийн санхүүжилтээс зарцуулсан 9,888.2 мянган төгрөгийн зардлын дүнгээр урьдчилж орсон орлого, урьдчилж гарсан зардлыг тус тус /-/ утгатайгаар бууруулж тайлагнасан байна.	Завсрын аудитаар залруулсан.	1	19,776.6	1	19,776.6	-	-	-	-	-	-	-	-
8	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ-2022/70/Н А-СТА-ТШЗ	Санхүүгийн тайланд бусад өглөгийг сөрөг утгатайгаар тайлагнаж богино хугацаат өр төлбөрийг 8,956.1 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасан байна.	Завсрын аудитаар залруулсан.	1	8,956.1	1	8,956.1	-	-	-	-	-	-	-	-
9	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ-2022/70/Н А-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгөнд бараа материалын шинж чанартай 9 нэр төрлийн нийт 983.7 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна. Энэ нь санхүүгийн	Завсрын аудитаар залруулсан.	1	983.7	1	983.7	-	-	-	-	-	-	-	-

Цөмийн физик судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			тайлагналын хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.													
10	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	Өмнөх аудитаар тогтоосон 8,956.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулаагүй байна.	Завсрын аудитаар залруулса н.	1	8,956.0	1	8,956.0	-	-	-	-	-	-	-	-
11	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан 6 байгууллага , 2 иргэнд 3,830.4 мянган төгрөгийг шилжүүлэхдээ өглөг үүсгэхгүйгээр шууд зардлын дансанд бүртгэж тайлагнасан байна.	Завсрын аудитаар залруулса н.	1	3,830.4	1	3,830.4	-	-	-	-	-	-	-	-
12	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	Нийт 9 байгууллагын 24,141.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлээс 3 байгууллагын 24,082.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн	Залруулса н.	1	24,082.2	1	24,082.2	-	-	-	-	-	-	-	-

Цөмийн физик судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			актаар баталгаажуулааг үй байна.													
13	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	Нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 2 иргэний гадаад томилолтын зардал 7,080.0 мянган төгрөгийг зардлын дансаар тайлагнасан байна	Залруулса н.	1	7,080.0	1	7,080.0	-	-	-	-	-	-	-	-
14	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	Санхүүгийн байдлын тайлан дахь түлш шатах тослох материалын эцсийн үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулгын түлш шатах тослох материалаас 18.2 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	Залруулса н.	1	18.2	1	18.2	-	-	-	-	-	-	-	-
15	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	Тайлант хугацаанд 87,380.2 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 5 нэр төрлийн хөрөнгөнд 7,249.3 мянган төгрөгийн	Залруулса н.	1	7,249.3	1	7,249.3	-	-	-	-	-	-	-	-

Цөмийн физик судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			элэгдэл тооцоогүй байна.													
16	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан үндсэн хөрөнгийн ажиглах хугацааг баримтлаагүй 1 жилээр тооцсоноос нийт 43 нэр төрлийн 32,088.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үлдэх өртөггүй тайлагнасан байна.	Залруулса н.	1	32,088.7	1	32,088.7	-	-	-	-	-	-	-	-
17	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 10 нэр төрлийн 7,291.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгө бүртгэлтэй байна.	Зөвлөмж өгөх	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
18	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар баталсан зардлын нэр төрлийн санхүүгийн программд нэмж оруулаагүй, нэмэлт санхүүжилтийн тайлан, төсвийн	Зөвлөмж өгөх	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-

**Цөмийн физик судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

			тохируулгын тайланг бэлтгээгүй байна.													
19	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	Санхүүгийн тайланд 65,800.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн тайланг бэлтгээгүй байна.	Албан шаардлага өгөх	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн					19	190,040.7	16	190,040.7	-	-	1	-	-	-	2	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	Цөмийн физикийн судалгааны төв нь тайлант хугацаанд 26,636.5 мянган төгрөг буюу 8 хувийн хэмнэлт гаргаж ажилласан боловч ЗГ-ын 43 дугаар тогтоолд заасан хувиас 2 хувиар дутуу байна.	Албан шаардлага өгөх	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
2	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ- 2022/70/Н А-СТА- ТШЗ	Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 9 мэдээлэл хугацаа хоцорч, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий	Хариуцлаг а тооцох албан шаардлага өгөх	1	44,891.8	-	-	-	-	1	44,891.8	1	44,891.8	-	-

Цөмийн физик судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			орлогын 4 удаагийн зарлагын 3 удаагийн 44,891.8 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй алдаа зөрчлийг давтан гаргасан байна.													
Дүн					2	44,891.8	-	-	-	-	1	44,891.8	1	44,891.8	-	-
НИЙТ ДҮН					21	234,932.5	16	190,040.7	-	-	3	44,891.8	1	44,891.8	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 104/АХГ-2022/70-НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

АХГ-2022/70/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цөмийн физикийн судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийн биелэлт, хүрсэн үр дүн түүний танилцуулга, төсвийн тохируулгын тайлан, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлангийн танилцуулгыг хуулиар заасан хугацаанд иж бүрэн хийж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна", 54 дүгээр зүйлийн 54.5.5 "Нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн, үнэн зөв бэлтгэж байх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цөмийн физикийн судалгааны төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Болортуяа, Нягтлан бодогч Б.Цагаанхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherel\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-1\14.Docx

0010800386



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 106 /А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/70/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цөмийн физикийн судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 10.1.7 "төсвийн хэрэгжилтэд хяналт тавих;" 10.1.11 "төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах;" Монгол Улсын Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1 "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг төвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөв захирагч нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цөмийн физикийн судалгааны төвийн дарга Д.Болортуяа, Нягтлан бодогч Б.Цагаанхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

1110.10.10.20\Bichig_Kherem\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-116.Docx

0010800392



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 105/А0150058
АХГ-2022/70/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цөмийн физикийн судалгааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 9 мэдээлэл хугацаа хоцорч, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4 удаагийн зарлагын 3 удаагийн 44,891,811.62 төгрөгийн мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитын шилэн данстай холбоотой өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй нягтлан бодогч Д.Цасчихэрт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цөмийн физик судалгааны төвийн захирал Д.Болортуяад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-115.Docx

00108C0389